



ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТШИРЭЭТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 03 сарын 31 өдөр

Дугаар 6/13

Батширээт сум

Д.Бүдхандыг түр орлон гүйцэтгэгчээр
томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн албаны тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.8, 43 дугаар зүйлийн 43.1, 43.3.3, 43.4, Засгийн газрын 2019 оны 09 дүгээр тогтоолын хавсралт "Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин урамшуулал олгох журам"-ын 2.4 дэх заалт, Авилгатай тэмцэх газрын 2025 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 05/6024 тоот албан бичгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Б.Эрдэнэчимэг нь тэтгэвэр тогтоолгох насанд хүрч 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөс төрийн албанаас чөлөөлөгдсөн тул 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдрөөс Нийгмийн бодлогын мэргэжилтэн Дашдоржийн Бүдхандыг Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилсугай.

2. Д.Бүдхандад түр орлон гүйцэтгэж байгаа албан тушаалын цалингийн 40 хувиар тооцон олгохыг нягтлан бодогч (Б.Цолмон)-д зөвшөөрсүгэй.

3. Ажил хүлээлцэх ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.
Үүнд:

Ахлагчаар: Б.Мөнх-Очир - Байгаль орчны хяналтын улсын
байцаагч

Гишүүдэд: Г.Энхбат – Санхүүгийн албаны дарга
Б.Номинжаргал – Нярав

4. Ажлын хэрэгцээнд ашиглаж байсан компьютер тоног төхөөрөмжийг хүлээлцэн холбогдох бичиг баримтыг хүлээлцэн танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Мөнх-очир)-т даалгасугай.



ЗАСАГ ДАРГА

БАЛТАНГЭРЭЛ

232501018